

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04-р сарын 24-ний өдрийн Баасан гаригт 10.00 цагт Улаанбаатар хот, АСБИ ХК-ны байранд мэссэнжэр чат ашиглан онлойнаар зохион байгуулав. Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчээс 10 хувьцаа эзэмшигч оролцсон нь 61,001 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 96,1% болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69.1-т зааснаар ХЭХ хуралдуулах ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болсныг тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн мэдээлэв.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
4. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2020 оны зардлын төсөв батлах

АСБИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурал:

Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, хурлын ирцийг Тооллогын комиссийн дарга Б.Доржсүрэн:
-ХЭХ-ийн ирцийг танилцуулья.

Нийт 57 хувьцаа эзэмшигчээс 10 хувьцаа эзэмшигч онлайн хуралд оролцож байна. Энэ нь нийт саналын 96.1% хувь болж байгаа тул хурал хүчин төгөлдөр болж байна.

Хурал нээж Д.Лхагвасүрэн:

-Ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн тул хурал нээснийг мэдэгдье.
Энэ удаагийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг POWER POINT хэлбэрээр танилцуулав.

Хэлэлцэх асуудал 1. -Компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 61,001 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал 2. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
Гишүүдийн танилцуулгыг танилцуулж хүргүүлсэн байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Д.Лхагвасүрэн 61001 ширхэг буюу 100%-ийн санал
2. Л.Сүмбанд 61001 ширхэг буюу 100%-ийн санал
3. Ч.Дашцэрэн 61001 ширхэг буюу 100%-ийн санал
4. С.Буман-Эрдэнэ 61001 ширхэг буюу 100%-ийн санал
5. Б.Доржсүрэн 61001 ширхэг буюу 100%-ийн санал
6. Л.Түвшинзаяа 61001 ширхэг буюу 100%-ийн санал

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Э.Буянтогтох 61001 ширхэг буюу 100%-ийн санал
2. Ц.Хадаа 61001 ширхэг буюу 100%-ийн санал
3. Л.Нямдаваа 61001 ширхэг буюу 100%-ийн санал тус тус 100%-ийн санал өгсөн байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалт, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй болж байна.

Хэлэлцэх асуудал 3. - Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2020 оны зардлын төсөв батлах

Энэ жилийн ТУЗ-ын төсвийг өнгөрсөн жилийн төсөвтэй ижил байхаар 7,000,000 сая төгрөгөөр батлуулахаар оруулсан байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 61,001 ширхэг 100%


Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоол баталж, Хурлын дарга Д.Лхагвасүрэн дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар ХЭХ-ын тогтоол тус бүрийг уншиж танилцуулан батлав.

Ийнхүү энэ удаагийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН
О.БИЛГҮҮН
Б.ДОРЖСҮРЭН